

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Үндэсний баялгийн үнэ цэнийг нэмэгдүүлж, стратегийн ашигт малтмал болон хүнд үйлдвэрийн салбарын нэгдсэн бодлого, үр ашигтай менежментийг хэрэгжүүлэх замаар экспорт, төсвийн орлого, валютын нөөцийг өсгөж, хэрэглэгчид болон хамтрагчдад итгэл хүлээсэн, өрсөлдөх чадвартай уул уурхайн салбарыг хөгжүүлэх.

### Стратегийн зорилго:

1. Бизнесийн өсөлтийг чухалчлан үнэ цэнийг нэмэгдүүлнэ.
2. Үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангаж үр ашгийг нэмэгдүүлнэ.
3. Эрчим хүчний шинэ эх үүсвэртэй болох стратегийг хэрэгжүүлнэ.
4. Сайн засаглал, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлнэ.

### Стратегийн зорилт:

#### Зорилт 1

#### Байгалийн баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах

- ❖ Эдийн засгийн үр ашигтай, бэлэн байдал хангагдсан хайгуул, олборлолтын төслүүдэд хөрөнгө оруулалт татаж хөрөнгө оруулалтын урсгал эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- ❖ Чухал ашигт малтмал, газрын ховор элементийн нөөцийг өсгөх зорилгоор хэтийн төлөв бүхий талбайд тойм судалгааны ажлыг гүйцэтгэж, тусгай зөвшөөрөл эзэмшинэ.
- ❖ Өндөр технологи бүхий улс орнууд, хөрөнгө оруулагчидтай чухал ашигт малтмал, газрын ховор элемент, литийн хайгуул, олборлолт, баяжуулалт, боловсруулалтын чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлж, үндэсний чадварлаг хүний нөөцийг бэлтгэнэ.
- ❖ Газрын ховор элементийг нийлмэл исэл хэлбэрээр гарган авах баяжуулах, боловсруулах лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт судалгааг гүйцэтгэж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд бэлтгэнэ.
- ❖ Газрын ховор элемент, литийн ордыг олон улсын хөрөнгийн биржид гаргах зорилготой ажиллана.

#### Зорилт 2

#### Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих

- ❖ Аж үйлдвэрийн гинжин хэлхээг бүрдүүлэх стратегийн хүрээнд үндсэн түүхий эд боловсруулах суурь үйлдвэрүүдийн төслүүдийг хэрэгжүүлж, холбогдох дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийнэ.
- ❖ Өндөр өртөгтэй, нарийн технологид суурилсан төслүүдийг хэрэгжүүлэх хүрээнд энэ чиглэлээр тэргүүлэх туршлага, чадавх бүхий хөрөнгө оруулагчидтай харилцан ашигтай хамтран ажиллана.

#### Зорилт 3

#### Техник, технологийн сонголт, ашиглалтыг сайжруулах

- ❖ Үйл ажиллагааны хэвийн, найдвартай байдлыг хангах зорилгоор шаардлагатай хөрөнгө оруулалт хийж, өргөтгөл, шинэчлэлийн төслүүдийг хэрэгжүүлэх.
- ❖ Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өртгийг бууруулах зорилтын хүрээнд үр ашиг, өгөөж өндөртэй хөрөнгө оруулалтыг үе шаттай хэрэгжүүлэх.

#### Зорилт 4

#### Хөрөнгө оруулалт, төслийн удирдлагын механизмыг бүрдүүлэх

- ❖ Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өртгийг бууруулах зорилтын хүрээнд эдийн засаг, нийгмийн ач холбогдолтой, эдийн засгийн үр ашигтай, хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдсэн төслүүдэд үр ашиг, өгөөж өндөртэй хөрөнгө оруулалтыг үе шаттай хэрэгжүүлэх.
- ❖ Төслийн санхүүжилтийн тасралтгүй байдлыг хангах.
- ❖ Төслийн төлөвлөлт, уялдаа холбоо, нийцэл болон хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах.
- ❖ Төсөл, хөрөнгө оруулалтын багцын төрөлжилт, эрсдэлийн удирдлага, өгөөжийг нэмэгдүүлэх.
- ❖ Хөрөнгө оруулалтын эргэн төлөлтөд суурилсан санхүүжилтийн эх үүсвэрийг өсөлтийг хангах.